

# УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ

## ИЛТГЭХ ХУУДАС

№03 (2024)

Улаанбаатар хотын музейн орчны аюулгүй байдалд  
хяналт шалгалт хийсэн тухай

2024 оны 9 дүгээр сарын 02

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” 311 дүгээр тогтоол, Гар урлал болон урлагийн зориулалттай зүйлс. Музейн үйл ажиллагаанд тавигдах шаардлага MNS5634:2006 стандарт (цаашид музейн стандарт гэх) 17.5 дахь хэсэг, Музейн тухай хуулийн 4.14.1 дэх хэсэг, Улаанбаатар хотын музейн захирлын 2024 оны “Журам батлах тухай” А/11 дүгээр тушаал, 2024 оны музейн дотоод хяналт, шалгалт хийх ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Дотоод хяналт шалгалт хариуцсан ажилтан, Музейн захирал, Бүртгэл мэдээллийн санч, Эрдэм шинжилгээний ажилтан нар 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улаанбаатар хотын музейн аюулгүй байдлын үзлэг хийлээ.

Үзлэгийн гишүүд музейн хашааны төв хаалганаас эхлэн зүүн талаас баруун тийш тойрон үзлэг хийж, тэмдэглэл хөтлөн, зураг авч, хэрхэн шийдвэрлэх талаар ярилцлаа. (Үзлэгийн гэрэл зургийг хавсаргав.)

Музейн орчны аюулгүй байдлын үзлэг, шалгалтын үеэр илэрсэн зөрчлүүд, зөрчлийг хэрхэн арилгах талаар хүснэгтээр харуулбал:

Д/д	Илэрсэн зөрчлүүд	Гэрэл зураг	Зөрчлийг хэрхэн арилгах
1.	Музейн хойд талаас хашаа руу ордог төв хаалганы доод талд тогтоосон нарийн төмөр нь хөндийрсөн, орох хэсгийн цементэн талбай нь ухагдсан тул орж гарч буй машины доод эд ангийг гэмтээх аюултай байна.		Орох талбайг цементлэн битүүлж, нарийн төмөрийг суурь цементэд суулгах
2.	Хашааны төв хаалгыг ажлын бус цагаар цоожлоогүйн улмаас хүн хаалга налах, хүрэх үед хаалга өөрөө нээгдэх зэрэг эрсдэл үүсдэг.		Хашааны гадаах хаалгыг ажлын бус цагаар цоожлож хэвших, шинээр цоож худалдан авах (Музейн жижүүрийн аюулгүй байдлыг хангах)

3.	Музейн хойд талаас хашаа руу ордог төв хаалганы төмрийн гагнаас салсан.		Хаалганы салсан төмрийг яаралтай гагнуулах
4.	Гарц хааж машин тавихыг хориглоно гэсэн тэмдэг тэмдэглэгээ нь бүдгэрсэн, нам дор байрлуулснаас орж ирж буй машинд харагдахгүй байна.		Гарц хааж машин тавихыг хориглоно гэсэн тэмдэг тэмдэглэгээг шинээр худалдан авах, орж ирж буй машинд харагдахаар өндөрт гагнаж байрлуулах
5.	Музейн хашааны зүүн талд байрлах Худалдаа Хөгжлийн банкны агааржуулагч төхөөрөмж нь хазайж музейн хашааг налж унагах эрсдэлтэй байна.		Худалдаа Хөгжлийн банкинд албан ёсоор мэдэгдэж яаралтай янзлуулах
6.	Сан хөмрөгийн өрөөний үүдэнд салангид хэдэн ширхэг тоосгоор довжоо хийсэн, энэ нь сан хөмрөгт орж буй хүний хөлөөр тээгдэн шавар шавхай өрөөнд орж ирэх, үзмэр зөөвөрлөхөд эрсдэл үүсгэж болзошгүй.		Сан хөмрөгийн өрөөний үүдэнд шинээр довжоо хийх, довжоог налуу байдлаар хийж үзмэр зөөвөрлөхөд аюулгүй байхаар шийдэх
7.	Сан хөмрөгийн өрөөний цонхны гадна талын шил хагарсан нь сан хөмрөгийн өрөөний аюулгүй байдлыг зөрчиж байна.		Хагархай шилийг яаралтай сольж шинээр шиллэх

8.	Узелийн дээврийн дээд хэсэгт хог хураасан байна.		Узелийн дээврийн дээд хэсэгт овоорсон хогийг яаралтай цэвэрлэх, ачуулах, энд дахин хог хаяхгүй байх
9.	Узелийн хажууд ургаж буй модны мөчир нь узелийн дээвэр лүү далийж ургасан байна.		Далийж ургасан модны мөчрийг тайрч, хогонд ачуулах
10.	Сан хөмрөгийн өрөөнөөс музейн үзүүлэгийн танхим руу чиглэсэн явган зам нь эвдэрсэн тул үзмэр зөөж тээвэрлэхэд эрсдэлтэй байна.		Явган замын дутууг нөхөн засч янзлах
11.	Узелийн өрөөг цэвэрлэх, самбар, тумбочка, сандал зэрэг ашиглалтын хугацаа дууссан, музейд бүртгэлгүй тоног төхөөрөмжүүдийг хаялгүй энэ өрөөнд хадгалсан нь гал гарах эрсдэл үүсгэж байна.		Узелийн өрөөг цэвэрлэх, хуучин эд зүйлсийг энэ өрөөнд хадгалалгүй хаяж хэвших
12.	Галын сарайг 2024 онд засч янзлан, дутуу байсан гал унтраах төхөөрөмжүүдийг шинээр худалдан авч бүрдүүлсэн. Сарай хог хаягдал ихтэй байна.		Галын сарайнд цэвэрлэгээ хийх тоос шороо, эргэн тойронд хаясан хогийг цэвэрлэх

<p>13.</p>	<p>Музейн барилга нь нийт ус зайлуулах 12 хоолойтой. Үүнээс: Музейн барилгын нүүрэн хэсэг: Ус зайлуулах 4ш хоолойтой. Хоолойнууд муудаж, цоорсон. Хойд хэсэг: Ус зайлуулах 5ш хоолойтой. Хоолой нь муудсан, ус зайлуулагч нэг хоолой мултарч унасан ба бороо цасны ус хөлдөж оффисийн үүдэнд хүн халтирч унах эрсдэл үүсгэдэг, 1 хоолой дутуу Зүүн хэсэг: Ус зайлуулах 1ш хоолойтой. Хоолой зэвэрч муудсан. Урд хэсэг: Ус зайлуулах 2ш хоолойтой, зэвэрч муудсан, дутууг хуванцар хоолой залгасан.</p>		<p>Ус зайлуулах хоолойнуудыг сэргээн засварлах, дутууг яаралтай нөхөх</p>
<p>14.</p>	<p>Музейн дээврийн төмөр олон жил сэргээн засварлаагүйн улмаас ниймгэрч, зарим хэсгээрээ цоорч музейн жижүүрийн хэсэг, ариун цэврийн өрөө, 3 дугаар танхимд дусаал гоождог. Үзмэрийн хадгалалт хамгаалалтын байдалд эрсдэл үүсч байна.</p>		<p>Дээврийн төмрийг яаралтай сэргээн засварлах, дусаал гоождог цоорхой хэсгийг нөхөх шаардлагатай.</p>
<p>15.</p>	<p>Онъ тэнгэрийн бичиг ХХК 2022 онд цахилгааны утас цэгцлэх ажлыг хийсэн. Музейн барилгын урд хэсэгт байрладаг цахилгааны 2 шит нь ажиллагаа хэвийн, цахилгааны утаснууд цэгцтэй, утас дарагчаар нэгтгэн багласан. Жижиг шит нь түлхүүргүй, хаалга нь онгорхой байна. Галын</p>		<p>Цахилгааны жижиг шитний түлхүүрийг олж хаалгыг цоожлох, түлхүүрийг музейн жижүүрт хүлээлгэн өгөх</p>

	аюулгүй байдлыг хангаагүй байна.		
16.	Музейн хашаанд контор №1 өрөөний баруун талын мод тарьсан хэсгийн төмөр хашлаганы гагнаас салсан.		Хашлага дээр хүн суусан тохиолдолд унах аюултай тул салсан хэсгийг яаралтай гагнуулах
17.	Музейн хашаанд үзэгчдэд зориулан 2021 онд энэхүү гадаах номын санг байрлуулсан ба номын сангийн хаалганы цоож эвдэрч, шил хагарсан.		Монголын нөхцөлд гадаах номын сан зохимжгүй байна. Мөн байгууллагын өнгө үзэмжид муугаар нөлөөлж байна. Тиймээс байгууллагад бүртгэлгүй тул устгалд оруулах
18.	Музейн хашаанд, ажилтнуудын өрөөнд хулгана үзэгдсэн тул хулганы наадаг хор, хулганы хавх худалдан авч музейн ажилтнуудын өрөө, сан хөмрөгийн өрөөнд байрлуулсан ба сан хөмрөгийн өрөөнд тавьсан наадаг хоронд батгана, ялаа наалдсан, ажилтнуудын өрөөнд тавьсан наадаг хоронд хулгана наалдаж үхсэн байсан. Тиймээс музейн арга зүйч бусад музей болон шавж устгалын байгууллагын судалгаа хийн Orkin Mongolia гэх байгууллагаас мэргэжилтэн урьж үзлэг хийлгэсэн. Тухайн байгууллагаас 4.5 сая төгрөгийн үнийн санал илгээсэн. (Хавсралт №1) Гэвч музейн төсөвт тухайн зардал байхгүй.	  	Ирэх жилийн төсөвт хулгана мэрэгчийн тогтмол хяналт, устгал хийлгэх төсөв суулгах, өөрсдийн боломжид тулгуурлан хяналт тавьж ажиллах Мөн хулгана мэрэгч үргээгч цахилгаанд залган ашигладаг төхөөрөмж 10 000 – 30 000 төгрөгийн өртөгтэй байдаг юм байна. Үүнийг авч ашиглах нь зүйтэй гэж үзэж байна.

19.	Соёлын яам, Бодь Электроникс ХХК хооронд СОЯ/202212021 тоот гэрээ байгуулагдаж, 2023 оны 09 дүгээр сард камер болон дохиолол хамгааллын системийг шинэчлэн суурьлуулсан. Музейн гадна 4ш камер суулгасан ба хэвийн ажиллаж байна.		Камерын үйл ажиллагааг сар тутам шалгаж хэвших
20.	Музейн барилга нийт 16 ширхэг цонхтой. Үүнээс: нүүрэн хэсэгт: 3ш цонхтой, Зүүн жигүүр 5ш цонхны хаалтыг оройн цагаар цоожлох цоожтой, урд хэсэг 2ш цонхтой, цонхнууд бүгд хамгаалалтын тортой. Барилгын баруун хэсэг 6 цонхтой, бүх цонхыг дарж хаах даруулга төмөртэй.		Цаашид бүх цонхны хаалтыг цоожтой болгох

Цаашид авч хэрэгжүүлэх ажлын санал:

Энэ удаагийн үзлэгээр илэрсэн дээрх хүснэгтэд бичсэн зөрчлүүд болон зөрчлийг хэрхэн арилгах арга зүйтэй танилцан музейн захирлын дэргэдэх захиргааны зөвлөлөөр хэлэлцэн холбогдох мэргэжилтнүүдэд үүрэг өгч шийдвэрлэж өгнө үү

ТАНИЛЦСАН:

ЗАХИРАЛ ..... П.ДАВААСҮРЭН

ГИШҮҮД:

..... Ч.ӨСӨХЖАРГАЛ

(Бүртгэл мэдээллийн санч)

..... Г.Очбаяр

(Эрдэм шинжилгээний ажилтан)

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН: ..... Б.ӨЛЗИЙБАЯР (Арга зүйч)

МУЗЕЙН ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЛЭГ ХИЙЖ БУЙ ГЭРЭЛ ЗУРАГ

